

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

МОНГОЛ УЛС ДАХЬ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Дүн шинжилгээ
(СТ-16/501)

ЗАХИАЛАГЧ: Хэлтсийн санаачилгаар

ХЯНАСАН: Ц.НОРОВДОНДОГ

СУДЛААЧИД: Ц.Болормаа
Ч.Онончимэг
Д.Халиун

Улаанбаатар
2016 он

**МОНГОЛ УЛС ДАХЬ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ
ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

Агуулга

1. Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчин
 - a. *Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг зохицуулсан байдал*
 - b. *Татварын орчин*
 - c. *Жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага*
2. Санхүүжилт
 - a. *Сум хөгжүүлэх сан*
 - b. *Зээлийн батлан даалтын сан*
 - c. *Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан*
3. Эмэгтэй эзэнтэй ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-ийн дунд явуулсан санал асуулгын дүн
4. Дүгнэлт
5. Ашигласан материал

Хавсралт 1 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд явуулсан санал асуулга

Хавсралт 2 Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн жагсаалт

1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2007 онд УИХ-аар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль баталсан бөгөөд тус хуулиар:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, түүний бүртгэл,
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй этгээд,
- Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх,
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн эрх үүрэг,
- Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэл,
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын тухай харилцааг зохицуулсан байна.

Түүнчлэн, салбарын дараах 14 хууль тогтоомжоор жижиг, дунд үйлдвэртэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үүнд:

1. Зээлийн батлан даалтын тухай хууль,
2. Инновацийн тухай хууль,

3. Засгийн газрын тусгай сангийн тухай,
4. Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль,
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,
6. Санхүүгийн түрээсийн тухай хууль,
7. Компанийн тухай хууль,
8. Нөхөрлөлийн тухай хууль,
9. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль,
- 10.Татварын ерөнхий хууль,
- 11.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
- 12.Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- 13.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
- 14.Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль зэрэг нийт 15 хууль тогтоомж үйлчилж байна.

Харин ЖДҮ-ийн салбарын харилцааг зохицуулж буй УИХ-ын 16 тогтоол, Засгийн газрын 24 тогтоол байгаагаас 2014 онд Засгийн газраас баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр”-ийг тусгайлан авч үзэх болно.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн тухайд хэдийгээр салбарын харилцааг зохицуулах бие даасан хууль батлагдсан нь сайшаалтай боловч төрөөс ЖДҮ-ийн салбарт баримтлах бодлогыг зохицуулсан гол зохицуулалт нь хэт ерөнхий, тодорхойгүй, тунхагын шинж чанартай зохицуулалт байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулж, зарим тохиолдолд зогсонги байдалд оруулж байна.

Иймээс хуульд төрөөс ЖДҮ-ийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг хэрхэн хуульчилсан, мөн хууль тогтоомж дахь ЖДҮ-ийн татварын орчин, ЖДҮ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын талаар тусгайлан авч үзье.

а) Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг зохицуулсан байдал:

Хуулийн 5 дугаар бүлэгт төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг хуульчилсан бөгөөд дараах бодлого баримтлахаар заасан байдаг. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бизнесийн шинэчлэл, шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих;
- Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн нөөц, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн тогтвортой байдлыг хангах, бизнесийг хувирган өөрчлөх боломжийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах бодлого баримтална.

гэснээс үзэхэд “таатай нөхцөлийг бүрдүүлэх”, “үйл ажиллагааг дэмжих” гэдэг нь

хэт ерөнхий, тодорхойгүй, тунхагын шинж чанартай байгаа юм.

Түүнчлэн, бизнесийн шинэчлэл, шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд төрөөс дараах дэмжлэг үзүүлэхээр заасан:

- шинэ бүтээгдэхүүн бий болгох, шинэ үйлчилгээ нээхэд шаардагдах технологийн хөгжлийн талаарх судалгааг дэмжих;
- бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон борлуулалтын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн түрээс зэрэг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах;
- шинэ бүтээгдэхүүн бий болгох, түүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг нэгтгэн удирдах удирдлага, менежментийн шинэ аргыг нэвтрүүлэхийг дэмжинэ.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг шинээр бизнес эрхлэхэд дараах дэмжлэг үзүүлнэ:

- шинээр бизнес эрхлэхэд шаардагдах мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;
- жижиг, дунд үйлдвэр эрхлэх хэрэгцээ, шаардлага, ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх;
- шинээр бизнес эрхлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрээр хангана.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүтээлч үйл ажиллагааг дараах арга хэмжээгээр дэмжинэ:

- бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх шинэ технологийн хөгжлийн талаарх судалгааг дэмжих;
- шаардлагатай хөрөнгийг хувьцаа, бонд гаргах замаар бүрдүүлэх тогтолцоог бий болгох;
- бүтээлч үйл ажиллагаанд шаардагдах боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх байдлаар дэмжинэ.

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийг дэмжих, өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах үүднээс санхүүгийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, даатгалын тогтолцоог хөгжүүлэх;
- банк болон банк бус санхүүгийн байгууллагатай тохирсны үндсэн дээр жижиг, дунд үйлдвэрт зориулсан санхүүжилтийг бий болгох;
- урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох;
- зээлийн баталгаа, батлан даалт гаргах;
- зарим төрлийн даатгалд хамруулах;
- гадаадын болон олон улсын байгууллагын санхүүжилт бүхий төсөл, тусламжийн арга хэмжээнд хамруулна.

Жижиг, дунд үйлдвэрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтын тогтолцоог боловсронгуй болгох, татварын ачааллыг зохицуулах арга хэмжээ авна.

б) Татварын орчин

ЖДҮ-ийн татварын орчны хувьд төрөөс тусгайлсан дэмжлэг, хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй бөгөөд бусад хуулийн этгээдийн адилаар татварын багц хуульд заасан хувь хэмжээгээр татвар болон нийгмийн даатгалыг төлж байна. Харин 2009 оноос эхэлсэн жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн зохицуулалт үйлчилж байсан. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2015 онд шинэчлэн баталсан бөгөөд “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө” гэж заажээ. Түүнчлэн, 2016 онд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулга УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд явж байна.

- *Жижиг дунд бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих:*

Монгол Улсын татварын шинэчлэлийн нэг гол зорилго нь аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд татварын таатай орчинг бий болгосноор иргэдэд ажлын байрыг бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм.

Өнөөгийн үйлчилж буй татварын багц хуулиудын хувьд ихэнх нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн, туршлага багатай үед боловсруулснаас сүүлийн үед маргаантай асуудлууд ихээхэн гарах болсон, мөн нэмэлт өөрчлөлт их ордог оос хуулийн зарим заалтуудын хувьд энгийн хүнд ойлгоход хүндрэлтэй болсон нь харагддаг.

1990 оноос хойш батлагдсан татварын хууль болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг судлан үзэхэд татварын төрлийн хувьд давхардсан тоогоор нийт 101 төрлийн хууль батлагдсанаас 46 төрлийн хууль нь хүчингүй буюу үйлчлэл нь дуусгавар болж, 55 төрлийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Татварын хуульд нийтдээ 232 удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 668 төрлийн нэмэлт, өөрчлөлт оруулсны 53% нь Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг өөрчилсөн өөрчлөлт, 22% нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой өөрчлөлт эзэлж байгаа нь татварын тэгш, шударга, тогтвортой байх зарчмыг үндсэнд нь алдагдуулсан гэж үзэж болохоор дүр зураг гарч байна.

Түүнчлэн ЖДҮ-ийн үйл ажиллагаанд татварын албаны хэмжээнд татвар төлөгчидтэй харилцах харилцааг зохицуулах зорилго бүхий 109 журам, заавар, аргачлал мөрдөгдөж байна.

Мөн татварын хууль тогтоомжийн хувьд татварын харилцааг зохицуулж, агуулгын хувьд давхардал үүсгэж байгаа нь иргэд, аж ахуй нэгжийн төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг бууруулан, хүнд суртлыг бий болгож, татвар төлөгчийн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулж байгаа юм.

Нийгэм, эдийн засгийн харилцаа өөрчлөгдөхийн хирээр татварын хууль тогтоомжийн зарим зүйл, заалт шинээр гарч ирж буй нөхцөл, шаардлага,

харилцааг зохицуулахад учир дутагдалтай болж ойлголтын зөрүү үүсч, уялдаа холбоогүй болох, улмаар татвар төлөгч, татварын албаны хооронд маргаан гарах асуудал ихсэх хандлагатай байна.

Татварын маргаан таслах зөвлөлд сүүлийн 5 жилийн байдлаар шийдвэрлэгдсэн судалгаанаас үзэхэд 274 татвар төлөгчид хамаарах 726,135.2 сая төгрөгийн маргааныг шийдвэрлэснээс татвар төлөгчийн талд 66.8%-ийг нь шийдвэрлэсэн дүн мэдээ гарсан бол Дэлхийн банкнаас хийгдсэн Бизнес эрхлэлтийн судалгаагаар татварын дарамтын хувьд манай улс сүүлийн жилүүдэд байнга ухарсан үзүүлэлт гарсан байна.

Тиймээс татварын багц хуулиудыг шат дараатай шинэчлэх, татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, татварын таатай орчинг бий болгох хүрээнд УИХ-аас 2015.07.09-нд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд өргөн баригдаад байна.

в) Жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Хуулийн 3 дугаар бүлэгт жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, түүний эрхийн тухай хуульчилсан байдаг. Одоогоор жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Аж үйлдвэрийн яамны “Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар” юм. Тус газар нь жижиг, дунд үйлдвэрийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээнэ. Энэ үндсэн үүргийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүй, бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, жижиг, дунд үйлдвэрийг аж үйлдвэрийн нэгдсэн бодлоготой уялдуулах, кластераар хөгжүүлэх, шинжлэх ухаан–төр–бизнес хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах, бизнес инкубаторын тогтолцоог хөгжүүлэх, борлуулалтын сүлжээг дэмжих сургалт, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, жижиг дунд үйлдвэрийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, татвар, зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сайдын эрхлэх ажлын хүрээний жижиг дунд үйлдвэрийн Засгийн газрын тусгай сан болон сум хөгжүүлэх санг удирдлага, зохицуулалтаар хангах, ахуйн үйлчилгээний салбарын эрх зүй, бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн талаар бодлогын судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлж байна.

“Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр”¹

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 278 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр” батлагдсан. Тогтоолд Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд жижиг, дунд үйлдвэрийн асуудалтай холбоотой зорилтуудыг тусгасан юм.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн талаарх асуудал нь аль ч улс орны хувьд хөгжлийн ямар ч шатанд авч үзэх, шийдвэрлэх шаардлагатай гол асуудлын нэг байдаг. Иймээс ч жижиг, дунд үйлдвэрийг 2014-2016 онд дэмжих хөтөлбөрийг боловсруулахдаа 2012 оны “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн улсын зөвлөгөөн”-ий зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2013 оны 154 дүгээр тогтоолоор баталсан “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрт жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, хөгжүүлэх талаар тусгасан зорилтуудтай уялдуулан боловсруулж жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж буй олон улсын туршлага, өөрийн орны онцлог, давуу тал, сул тал, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, түүхий эд, хүний нөөцийн боломж зэргийг харгалзан боловсруулсан байна.

Засгийн газраас 1999, 2005 онд баталж, хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүнд 2007 онд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль батлагдан эрх зүйн таатай орчин бүрдэж, санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэр нэмэгдэн, өрхийн болон хувиараа бизнес эрхлэгчдийн дунд албан ёсны жижиг, дунд үйлдвэр эрхлэх сонирхол, санаачилга идэвхэжсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн менежер, ажилтнуудын ур чадвар, чадамжийг хөгжүүлэх нь тухайн аж ахуйн нэгжийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байхад чухал нөлөө үзүүлдэг. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах нь ЖДҮ-ийн салбарт учирч байгаа томоохон асуудал бөгөөд санхүүгийн түрээс, факторинг, хувьцаагаар хөрөнгө оруулах зэрэг санхүүжилтийн бусад арга хэрэгслүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймээс дээрх асуудлуудыг цогцоор шийдэх, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэрийн чиглэлийн 15 зорилт, 43 үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан нэгдсэн зорилго, зорилт бүхий үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байна.

Тус хөтөлбөр нь ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгын

¹ Монголын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болоно олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг Хавсралт 2-с үзнэ үү.

хүрээнд дараах зургаан зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- хууль, эрх зүйн орчныг сайжруулах;
- кластераар хөгжүүлэх;
- судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх;
- жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах;
- санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүртээмжийг хангах;
- зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн тус хөтөлбөрийг улс даяар хэрэгжүүлжээ.


2. САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр хөтөлбөрт заасан байдаг. Үүнд:


- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Засгийн газрын бонд;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;
- Инновацийг дэмжих сангийн хөрөнгө;
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;
- Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр заасан.

Хөгжлийн банкнаас гаргасан мэдээлэлд 2019 он хүртэл Бондын мөнгөнөөс ЖДҮ-ийн салбарт 70 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөжээ.

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн тухайд нийт банк санхүүгийн байгууллагуудын жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээлийн хэмжээ 2,048 тэрбум төгрөг хүрч өмнөх оныхоос 5.9% хувиар буурсан байна. Иргэдэд олгосон зээлийн 15.7%-ийг ЖДҮ-д олгосон зээл эзэлж байна.



Иргэдийн зээлийн бүтэц (2015 оны 4 дүгээр улирлын байдлаар)



2009- 2015 оны хооронд ЖДҮ-д олгосон зээлийн хэмжээг харвал иргэд болон ААН-д олгосон зээлийн хэмжээ болон зээлдэгчдийн тоо нь доорх хүснэгтэд харуулсан бөгөөд 2015 оны 4 улирлын байдлаар байна.

	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Зээлдэгчдийн тоо-Иргэд	43094	45532	53331	50378	52947	57220	49945
Зээлдэгчдийн тоо-ААН	2229	2502	3308	3438	3660	4618	5232
ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээл	255636884	347544413	568858792	601363656	833434844	905541780	778684044
ЖДҮ ААН-д эрхлэгч олгосон зээл	227430818	277618137	473698455	590174081	971078774	1270618709	1270097395

/Монголбанк: мянган төгрөг/

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

	Аймаг, дүүрэг	Нийслэл	Бүс нутгийн хэмжээнд	Лизинг
Зээлийн хэмжээ	1-100 сая хүртэл	101-200 сая хүртэл	201 саяас дээш	100 сая хүртэл
Зээлийн хүү /жил/	7%	7%	7%	10.8%
Зээлийн хугацаа	5 жил	5 жил	5 жил	4 жил
Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа	1 жил	1 жил	1 жил	1 жил
Төсөл хүлээн авагч	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс	Нийслэлийн хөдөлмөрийн газар	Хөдөлмөрийн яам, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан	

Санхүүжилт болон хэрэгжилт

Эх үүсвэр	Зарцуулалт	Үр дүн
<ul style="list-style-type: none"> Улсын төсөв Олон Улсын зээл, тусламж Бусад эх үүсвэр 	<ul style="list-style-type: none"> Хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох Санхүүгийн түрээс /лизинг/ Зээлийн давхар 	<ul style="list-style-type: none"> Орон нутаг, бүс нутагт ЖДҮ-ийг хөгжүүлэх Ажлын байрыг нэмэгдүүлэх Импортыг орлох

<ul style="list-style-type: none"> • Зээлийн эргэн төлөлт • Засгийн газрын бонд 	батлан даалт	<ul style="list-style-type: none"> • бүтээгдэхүүн үйлдвэрлэх • Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
---	--------------	---

а) Сум хөгжүүлэх сан

Сумдад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2011 онд "Сум хөгжүүлэх сан"-г байгуулсан. Монгол улсын 330 суманд байгуулсан бөгөөд өнөөгийн байдлаар сумдад 150 саяас 1,0 тэрбум хүртэл төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна.

Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр тогтоосон байна. Үүнд:

- улсын төсвөөс олгох сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө;
- гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
- иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого.

Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар тогтоохоор заасан байна.

Улсын хэмжээнд 2013 онд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс нийт 7627 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 42,936.7 сая төгрөгийн зээлийг жилд 1-3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосноос 7521 зээлдэгчийн авсан 41,215.0 сая төгрөгийн зээл нь үр дүнгээ өгч шинээр 10677 байнгын ажлын байр, 1844 түр ажлын байр нэмэгдэж, 6892 ажлын байр хадгалагдсан байна.

Зээлийн ангилал		Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн /сая төг/	Эзлэх хувь
1	Хэрэгжиж байгаа төсөл	7521	41219.0	95.9
2	Төрийн албан хаагч авсан	11	37.8	0.09
3	Үйл ажиллагаа нь түр зогссон, эхлээгүй	29	1,393.2	3.4
4	Хүүгүй олгосон зээл	2	30.0	0.07
5	Харьяа газраа үйл ажиллагаа явуулаагүй	3	16.4	0.04
6	Явуулах үйл ажиллагаа тодорхой бус	61	240.3	0.5
Нийт дүн		7627	42,936.7	100.0

2014 онд Монгол Улсын Үндэсний Аудитын газрын Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн шалгалтаар шалгаруулсан нийт төслөөс 106 төслийн 1,717.7 сая төгрөгийн зээлийг "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих журам"-ыг зөрчиж шалгаруулсан байна.

б) Зээлийн батлан даалтын сан

Монгол Улсын "зээлийн батлан даалтын сангийн тухай" хууль 2012 онд батлагдсанаар барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах

эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд 2012 оны 11-р сарын 06-ны өдөр Сангийн дүрэм батлагдсанаар "Зээлийн Батлан Даалтын Сан" үүсгэн байгуулагдсан. Сангийн байгуулагч нь Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм. Сан нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах ба өнөөгийн байдлаар 250,0 сая хүртэл төгрөгийн батлан даалт гаргаж байна.

2015 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 364 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 59.6 тэрбум төгрөгийн зээлэнд 24.4 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргах шийдвэр гаргасан байна. Сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 250 сая төгрөг, доод хэмжээ 600 мянган төгрөг байна.



Зээлийн батлан даалтын сан нь 10 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 8 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэсэн. Нийт гаргасан батлан даалтын 25.5 хувийг Голомт банк, 21.2 хувийг Хас банк, 13.2 хувийг Хаан банкны зээлэнд тус тус гаргасан бөгөөд банкнаас олгосон дундаж зээлийн хэмжээ 164 сая төгрөг бол дунджаар зээлийн дүнгийн 48 хувьд нь батлан даалт гаргасан байна.

Батлан даалт олгосон байгууллагууд

№	Банк, санхүүгийн байгууллага	Батлан даалтын тоо	Батлан даалттай зээлийн хэмжээ /төгрөгөөр/	Батлан даалтын хэмжээ /төгрөгөөр/	Хувь
1	Голомт банк	93	18,240,010,000	7,820,385,000	25,5%
2	Капитал банк	47	6,894,900,000	2,789,793,400	12%
3	Төрийн банк	74	10,816,200,000	3,685,865,000	20,3%
4	ХААН банк	48	8,271,289,470	3,590,722,145	13,2%
5	Хас банк	77	8,649,000,000	3,817,361,000	21,2%
6	Чингис хаан банк	0	-	-	0%

7	Худалдаа хөгжлийн банк	22	6,498,600,000	2,631,434,000	6%
8	ҮХО-н банк	1	140,000,000	80,880,800	0,3%
9	Капитрон банк	2	192,500,000	57,092,500	0,5%
	НИЙТ	364	59,702,499,470	24,473,533,845	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

в) Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр төрөөс баримталж буй бодлогын хүрээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулж 5 хүртэл жилийн хугацаатай, жилийн 9 хувийн хүүтэй, эхний жилд үндсэн зээлийн төлбөрөөс 100 хувь чөлөөлөгдөж 2 дахь жилээс үндсэн зээлээ төлж эхлэх нөхцөлтэйгээр хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох мөн санхүүгийн түрээс буюу лизингээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглах боломжийг олгож байна.

3. ЭМЭГТЭЙ ЭЗЭНТЭЙ ЖДҮ ЭРХЛЭГЧ ИРГЭН, ААН-ИЙН ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН

Санал асуулга явуулсан хугацаа: 2016.02.29- 2016.03.02

Асуулгыг ЖДҮ эрхлэгч 10 иргэн, ААН-ээс авсан бөгөөд ингэхдээ ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийг сонгов. Судалгааны зорилгын хүрээнд 25 асуулт бүхий анкетын асуулга авч, фокус бүлгийн ярилцлага хийв.

Санал асуулгад оролцсон:

- **ЖДҮ эрхлэгч** иргэн – 3, хоршоо-3, ХХК-4
- Үйл ажиллагаа явуулж буй салбарын хувьд: үйлдвэрлэл үйлчилгээ-7, худалдаа-3
- Үйл ажиллагаа явуулж буй хугацааны хувьд: 1-13 жил
- Ажилчдын тооны хувьд: /1-9 ажилтантай/ – 7, /10-19 ажилтан/ - 3 тус тус байна.


Санал асуулгыг асуулт нэг бүрээр дүнг нэгтгэвэл:

- ААН, иргэнээр бүртгүүлэхэд хэр төвөгтэй байдаг вэ гэсэн асуултанд: Амархан – 5, Хэцүү – 3, маш хэцүү – 2
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахад хэдий хугацааг зарцуулсан бэ гэсэн асуултанд: Амархан – 2, Хэцүү – 2, маш хэцүү -6
- ЖДҮ эрхлэгч иргэн, ААН бүртгүүлсэн үү гэдэгт: бүртгүүлсэн – 2, үгүй -8
- Яагаад бүртгүүлээгүй вэ гэдэгт :бүртгэлийн сангийн талаар мэдэхгүй – 6, бүртгүүлэхэд чирэгдэл ихтэй – 2
- Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан ААН, иргэд 100 хувь үгүй гэсэн хариулыг өгсөн бөгөөд яагаад хамрагдаагүй талаар асуухад ЖДҮ-г дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдахад хүндрэл чирэгдэл ихтэй – 50%, хамрагдах хүсэлт гаргасан боловч хүлээж аваагүй гэдэгт-30%, тавигдах шаардлагыг хангасан

боловч хүлээж аваагүй -10%, тавигдсан шаардлагыг хангаагүй -10% хариултыг тус тус өгсөн байна.



- Төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа хөтөлбөрт хамрагдахад танд ямар бэрхшээл тулгарч байна вэ?
 - Төрийн байгууллагын хүнд суртал – 6 буюу нийт судалгааны хамрагдагсдын 30%
 - Авилга, хээл хахууль нэхдэг – 5 буюу 25 %
 - Ашиг сонирхлын зөрчил – 8 буюу 40%
 - Хүйсээр ялгавартай хандах хандлага – 1 буюу 5% байна.



- Та эмэгтэй бизнес эрхлэгчийнхээ хувьд төрөөс ямар нэгэн дэмжлэгт хамрагдаж байсан уу: Үгүй – 10
- Та бизнесээ ямар эх үүсвэрээр санхүүжүүлсэн бэ? Өөрийн хөрөнгөөр – 8, банкны зээлээр - 2
- Та ЖДҮ эрхлэгчийн хувьд төрөөс ямар дэмжлэгийг хүсч байна вэ?
 - Хөнгөлөлттэй зээл олгох - 4
 - Татварын урамшуулал – 6
 - Ажлын байрны урамшуулал – 3
- ЖДҮ эрхлэхэд зориулан олгодог зээлийн талаар та мэдэх үү?
 - Мэднэ - 8

- Мэдэхгүй – 2
- ЖДҮ эрхлэх зориулалтаар олгож буй зээлийн талаарх таны бодол?
 - Хүү өндөр -2
 - Хугацаа богино -0
 - Зээлд хамрагдахад тавигдах шаардлага өндөр -3
 - Зээлд хамрагдахад танил тал шаардлагатай - 8
 - Авилга хээл хахууль – 2
 - Ялгавартай хандлага-0
- ЖДҮ-г дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахад тулгарч буй бэрхшээл?
 - Бичиг баримт бүрдүүлэлт - 4
 - Барьцаа хөрөнгө хангалтгүй - 3
 - Зээлийн гэрээ хатуу - 1
 - Зээлийн эх үүсвэр хүрэлцдэггүй -1
 - Мэдэхгүй -1
- Таны бизнесийн үйл ажиллагаанд аль нь хамгийн их хүндрэл учруулж байна вэ?
 - Хууль эрх зүйн орчин - 0
 - Төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал - 8
 - Татвар – Хяналт шалгалт - 10
 - Санхүүжилт - 4
- ЖДҮ явуулахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?

Өөрийн хөрөнгөгүй

Зээл олдохгүй

Эдийн засгийн байдал хүнд /Худалдан авах чадвар

Мөнгөний ханшны уналт

Засгийн газрын дэмжлэг муу

Тоног төхөөрөмж худалдан авах чадвар хомс


Өөрийн гэсэн ажлын байргүй

Татварын дарамт их

Төрийн байгууллагын хяналт шалгалт их

Албан тушаалтны хууль бус хандлага

- ЖДҮ-г хөгжүүлэх сангаас танд хүрч ажиллаж чадаж байна уу.
Үгүй – 10
- ЖДҮ-г хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг та хэрхэн дүгнэж байна вэ?
Хангалтгүй – 10
- Та Эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдэх үү?
Мэдэхгүй – 10
- Төрөөс эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг үү?
Хэрэгтэй – 8
Хэлж мэдэхгүй байна – 2



ДУГНЭЛТ

Судалгаанаас үзвэл манай улсын хувьд ААН-ээр бүртгүүлэх нь чирэгдэл багатай, хэдий ч төрийн байгууллагаас үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах нь нэлээдгүй төвөгтэй байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд ЖДҮ эрхлэгчдэд дараах бэрхшээл бодитойгоор тулгарч байна.

- **Төрийн байгууллагын хүнд суртал:** Тухайлбал төрийн болон орон нутгийн зүгээс зохион байгуулж буй төсөл, хөтөлбөрт хамрагдахад зардал чирэгдэл ихтэй, холбогдох байгууллага, албан тушаалтан нь зөвлөгөө мэдээлэл өгдөггүй, бичиг баримтыг цаг тухай бүрт нь хүлээн авч шийдвэрлэдэггүй зэрэг хүнд суртал үүсдэг байна.
- **Авилга хээл хахууль:** ЖДҮ дэмжих зээл болон төсөл хөтөлбөрт шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, туслах ажилтан нь дэмжлэгийн 10-20 хувийг авилгад өгөхийг шууд шаарддаг. Нийтийн хоолны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эрх бүхий албан тушаалтан бараа бүтээгдэхүүнийг үнэ хөлсгүйгээр авах, үйлчлүүлэх гэсэн дарамт байнгын шинжтэй байдаг.
- **Ашиг сонирхлын зөрчил:** Төрөөс ЖДҮ-ийг дэмжих төсөл, хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгааг ЖДҮ эрхлэгчид мэддэг хэдий ч хамрагдах сонирхол байдаггүй. Учир нь тавигдах шаардлагыг бүрэн хангасан хэдий ч танил талгүйн улмаас зээл, тусламж, төсөл хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байх нь элбэг. Тиймээс илүү цаг, зардал гаргах сонирхол байдаггүй нь ярилцлагын явцад ажиглагдлаа.
- **Татварын дарамт:** НӨАТ-ын буцаан төлөлттэй холбоотойгоор сарын цэвэр ашгаас хэд дахин давсан зардлаар шинэ тоног төхөөрөмж авахыг төрөөс шаарддаг. Түүнчлэн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх хууль эрх зүйн орчин байдаггүй.
- **Санхүүжилт:** Зээлийн хүү өндөр, зээл авахад шаардагдах барьцаа хөрөнгө их, хугацаа богино түүнчлэн зээл авахад танил талгүй бол зээл авах магадлал хомс байдаг. Нийт зээлийн дүнгийн 10-20 хувийг хахуульд өгсөн тохиолдолд ЖДҮ сангаас зээл авах боломжтой болдог нь амьдрал дээр бодитойгоор бий болсон байна. Энэ мэт хүндрэл бэрхшээлээс болж олон ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагаагаа зогсооход хүрдэг байна.
- **Бодлого, эрх зүйн орчин:** Хэдийгээр ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хууль, эрх зүйн орчин хангалттай болов ч бодит амьдрал дээр хууль эрх зүйн орчны хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Учир нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх дунд шатны байгууллагын зүгээс ЖДҮ эрхлэгч нарт бодитойгоор хүрч ажилдаггүй. Энэ нь дараах зүйлээр баталгаажиг байна.
 - 1/ Фокус бүлэгт хамрагдсан ЖДҮ эрхлэгч нарын ярилцлага;
 - 2/ УИХ-ын Тамгын газрын хуулийн хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий хяналт шалгалтын хэлтэст ЗГХЭГ-аас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн мэдээнээс үзэхэд ЖДҮ-ийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2015 оны байдлаар ямар ч мэдээлэлгүй байна;
 - 3/ ЖДҮ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Аж үйлдвэрийн яамны холбогдох газраас ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх 2014-2015 оны тайлан өдийг хүртэл эцэслэн гараагүй болно;

4/ ЖДҮ эрхлэгчдэд зориулсан байнгын мэдээллийн урсгал байхгүй. Өөрөөр хэлбэл хууль эрх зүйн орчны талаарх иргэдэд зориулсан хялбаршуулсан мэдээлэл, хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн мэдээлэл байхгүй, холбогдох төрийн байгууллагууд өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан эрх зүйн орчны талаарх мэдээлэл болон ЖДҮ талаарх тоон мэдээлэл байхгүй;

5/ Статистик тоон мэдээллийг гаргах эрх бүхий төрийн байгууллагын зүгээс бизнес регистрийн санд аж ахуйн нэгжийн тоон мэдээллийг гаргахдаа ЖДҮ ангилал, хүйсийн ангиллаар гаргадаггүй байна.

- **Төрийн албан хаагчийн ёс зүй:** Төрийн албан хаагчид хууль тогтоомжид заасан Төрийн албан хаагчийн ёс зүйг баримталдаггүй улмаас ЖДҮ эрхлэгчдэд ёс зүйн дарамт ирдэг байна. Тухайлбал, эрх мэдлээр далайлгах, айлган сүрдүүлэх, ашиг хонжоо хайх үүднээс эрхшээлдээ оруулахыг хүсэх үйлдлүүд тогтмол гардаг байна. Энэ нь ихэвчлэн төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг улсын байцаагч, өөрөө удирдах ёсны байгууллагад ажилладаг албан хаагчдаас гардаг ёс зүйн алдаа юм.
- **Жендэрийн мэдрэмжтэй бодлого:** Эмэгтэй бизнес эрхлэгч нарт хандсан төрийн болон болон төрийн бус байгууллага байхгүй, эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд энэ талаарх мэдээ мэдээлэл огт байхгүй байна. Энэ талаарх төрийн бодлого, зохицуулалт дутмаг байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГА
(Questionary)**

1-р хэсэг. Ерөнхий мэдээлэл

- Q1.** Компанийн нэр:
- Q2.** Үйл ажиллагааны салбар:
- Q3.** Үйл ажиллагаа явуулж буй хугацаа:
- Q4.** Ажиллагсдын тоо:

2-р хэсэг. ЖДҮ-ийг эхлүүлэх болон бүртгүүлэх

- Q5.** Та дараах ангиллаас өөрт тохирохыг сонгоно уу?
1. Хувиараа бизнес эрхлэгч иргэн
 2. Нөхөрлөл (гэр бүлийн гишүүдийг оролцуулан)
 3. ХХК
 4. Хоршоо
- Q6.** ААН бүртгүүлэх, бизнес эхлүүлэхэд хэр төвөгтэй байсан бэ?
1. Маш амархан
 2. Амархан
 3. Амархан биш
 4. Хэцүү
 5. Маш хэцүү
- Q7.** Үйл ажиллагаа явуулах /тусгай/ зөвшөөрөл авахад хэдий хугацааг зарцуулсан бэ?
1. Маш амархан (Миний хийх зүйл бараг байгаагүй) ажлын 1 өдөр буюу 8 цаг зарцуулсан
 2. Амархан (бага зэрэг ажиллагаатай боловч, хэцүү биш байсан) ажлын 3 өдөр буюу нийт 24 цаг зарцуулсан
 3. Амархан биш байсан (Нэлээн цаг хугацаа зарцуулах шаардлагатай болсон) ажлын 5 өдөр буюу 40 цаг зарцуулсан
 4. Хэцүү байсан (Нэлээн их ажил болсон) ажлын 5 өдөр буюу 40 цагаас илүү хугацаа зарцуулсан
 5. Маш хэцүү ажлын 5-аас дээш адар болсон

Q8. Та Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжээр бүртгүүлсэн үү?

1. Тийм
2. Үгүй

Q9. Үгүй бол яагаад?

1. Бүртгэлийн сангийн талаар мэдэхгүй
2. Бүртгүүлэхэд чирэгдэл ихтэй
3. Амжаагүй
4. Бүртгэхээс татгалзсан
5. Бусад

3-р хэсэг – Дэмжлэг, санхүүжилт

Q10. Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан уу?

1. Тийм
2. Үгүй

Q11. Үгүй бол яагаад?

1. Дэмжлэг, хөтөлбөрийн талаар мэдэхгүй
2. Дэмжлэг, хөтөлбөрт хамрагдах нь хүндрэл, чирэгдэлтэй
3. Хамрагдахаар хүсэлт гаргасан боловч тавигдах шаардлагыг хангаагүй
4. Бусад

Q12. Та төрөөс ЖДҮ-г дэмжих аливаа хөтөлбөрт хамрагдахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?

1. Төрийн байгууллагын хүнд суртал
2. Авилга, хээл хахууль
3. Ашиг сонирхлын зөрчил
4. Хүйсээр ялгавартай хандах хандлага
5. Бусад

Q13. Та эмэгтэй бизнес эрхлэгчийнхээ хувьд төрөөс ямар нэгэн дэмжлэгт хамрагдаж байсан уу?

1. Тийм /Тийм бол ямар:...../
2. Үгүй

Q14. Та бизнесээ ямар эх үүсвэрээр санхүүжүүлсэн бэ?

1. Өөрийн хөрөнгөөр
2. Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөр
3. Бондын мөнгөөр
4. Орон нутгийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр

5. Банкны зээл
6. ББСБ-ийн зээл
7. Олон улсын байгууллагын зээл, тусламж
8. Бусад.....

Q15. Та ЖДҮ эрхлэгчийн хувьд төрөөс ямар дэмжлэгийг хүсч байна вэ?

1. Хөнгөлөлттэй зээл олгох
2. Татварын урамшуулал
3. Ажлын байрны урамшуулал
4. Бусад.....

Q16. ЖДҮ эрхлэхэд зориулан олгодог зээлийн талаар та мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

Q17. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгож буй зээлийн талаарх таны бодол?

1. Хүү өндөр
2. Хугацаа богино
3. Зээлд хамрагдахад тавигдах шаардлага өндөр
4. Зээлд хамрагдахад танил тал шаардлагатай
5. Авилга хээл хахууль
6. Ялгавартай хандлага
7. Бусад.....

Q18. ЖДҮ-г дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахад тулгарч буй бэрхшээл?

1. Бичиг баримт бүрдүүлэлт
2. Барьцаа хөрөнгө хангалтгүй
3. Зээлийн гэрээ хатуу
4. Зээлийн эх үүсвэр хүрэлцдэггүй
5. Мэдэхгүй
6. Бусад

4-р хэсэг – Хүндрэл бэрхшээл

Q19. Таны бизнесийн үйл ажиллагаанд аль нь хамгийн их хүндрэл учруулж байна вэ?

1. Хууль эрх зүйн орчин
2. Төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал
3. Татвар – Хяналт шалгалт
4. Санхүүжилт
5. Бусад

Жижиг, дунд үйлдвэрлэл явуулахад ямар бэрхшээл учирч байна вэ?		Тийм	Үгүй
1	Өөрийн хөрөнгөгүй		
2	Зээл олдохгүй		
3	Эдийн засгийн байдал хүнд /Худалдан авах чадвар		
4	Мөнгөний ханшны уналт		
5	Засгийн газрын дэмжлэг муу		
6	Улс төрийн нөлөөлөл их байдаг		
7	Тоног төхөөрөмж худалдан авах чадвар хомс		
8	Өөрийн гэсэн ажлын байргүй		
9	Татварын дарамт их		
10	Төрийн байгууллагын хяналт шалгалт их		
11	Албан тушаалтны хууль бус хандлага		
12	Бусад		

Q20. ЖДҮ-г хөгжүүлэх сангаас танд хүрч ажиллаж чадаж байна уу.

1. Тийм
2. Үгүй

Q21. ЖДҮ-г хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг та хэрхэн дүгнэж байна вэ?

1. Хангалттай
2. Хангалтгүй
3. Мэдэхгүй

5-р хэсэг – Эмэгтэй бизнес эрхлэгч

Q22. Та Эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

Q23. Төрөөс эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг үү?

1. Маш их хэрэгтэй
2. Хэрэгтэй
3. Хэлж мэдэхгүй байна

4. Шаардлагагүй

Q24. Таны хувьд цаашид ЖДҮ-ийг хөгжүүлэхэд төрийн ямар бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үздэг вэ?

.....
.....
.....
.....

САНАЛ ӨГСӨН ТАНД БАЯРЛАЛАА

АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР	
1. Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сан	<p>Зорилго: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх</p> <p>Зорилтууд: ЖДҮ эрхлэгчдэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох; төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах; ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх</p>
2. Жижиг, дунд үйлдвэрийг (2014-2016) дэмжих хөтөлбөр	<p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 278 дугаар тогтоолоор батлагдсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>Зорилт: Хууль, эрх зүйн орчныг сайжруулах; Кластераар хөгжүүлэх; Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх; Жижиг, дунд үйлдвэрийг чадавхжуулах; Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүртээмжийг хангах; Зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх</p>
3. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр (2014-2016)	<p>Засгийн газрын 2014 оны 08 сарын 28-ны 279 дүгээр тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвийн тоог нэмэгдүүлэн үйлчилгээг ойртуулах, ажилгүйдлийг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөнийг багасгахад оршино.</p> <p>Зорилт:</p> <ul style="list-style-type: none"> • Ахуйн үйлчилгээний төвүүдийг улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бий болгох; • төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; • албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой албан хөдөлмөрт шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг урамшуулах; • салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
4. Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр	<p>Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 299 дүгээр тогтоолоор "Монгол Улсыг үйлдвэржүүлэх" хөтөлбөрийг 2009-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Дотоодын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэн,</p>

олон тулгуурт эдийн засгийг бий болгож, улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

5. Арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээл

Арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой.

Зээлийн хэмжээ - АҮЯ-аас тогтоосон дүн

Зээлийн хугацаа - 5 жил хүртэлх

Зээлийн хүү (жил) - 7.0%

Тавигдах шаардлага:

1. АҮЯ-наас төсөл нь дэмжигдсэн байх;
2. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх;
3. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
4. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх;
5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх;
6. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

6. Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр 2009-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

Хөтөлбөрийн зорилго: Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол брэндийн органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэхэд оршино.

7. Монгол мал үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат 2010–2015 он, II үе шат 2016 – 2021 он) хэрэгжүүлэхээр баталсан.

Хөтөлбөрийн зорилго: Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

8. Чацаргана хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор “Чацаргана” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат-2010-2012 он, II үе шат-2013-2016 он) хэрэгжүүлэхээр баталсан.

Хөтөлбөрийн зорилго: Чацарганыг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр 20 мянган га хүртэл талбайд тариалж цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино.

9. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат 2003-2008 он, II үе шат–2009-2015 он) хэрэгжүүлэхээр баталсан.

ДОНОР ОРНУУД БОЛОН ОУБ-ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСЛҮҮД		
10.	Төслийн нэр, хэрэгжих хугацаа	Донор байгууллага
11.	Монгол төмс хөтөлбөр /2012-2015 он 2-р үе шат/ Төмсний үр үйлдвэрлэлийг үр ашигтай, тогтвортой болгон хөгжүүлж, үрийн хангалтын системийг төвлөрлөөс гаргаж, сайн чанарын үрийн хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар төмс үйлдвэрлэлийн үр ашгийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах болно.	Швейцарийн хөгжлийн агентлаг Төслийн баг Т.Төрмандах ХАА-н хоршоологчдын байр 115 тоот Утас:460158 contact@monpotatopro.mn
12.	Цаг Уурт дасан зохицсон хөдөөгийн амьжиргааг бүрдүүлэх /2012-2016 он/ Малчдын бүлэг өртөг нэмсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бусад орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрхлэх боломжтой болно. Орлогын төрлөө нэмэгдүүлэх нь байгаль цаг уурт өртөмхий мал аж ахуйгаас бага хамаарч цаг уурт зохицох зорилготой.	Азийн хөгжлийн банк Төслийнбаг Д.Нямдорж ЗГ-ын 11-р байр 708 тоот Утас: 70108810 99117994
13.	Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийг дэмжих Техник туслалцааны төслийн II үе шат /2014-2016 он/ Мал үржүүлэг зохиомол хээлтүүлэг, шувууны аж ахуй, хүлэмжийн аж ахуй, зөгийн аж ахуйн чиглэлээр БНХАУ-ын мэргэжилтнүүд аж ахуйн нэгжүүдэд ажиллаж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгнө.	НҮБ-ын ХХААБ, Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар Төслийн баг Г.Гантулга Хоршоологчдын хольооны байр, 501 тоот Утас:99175578
14.	Хөдөө аж ахуйн маркетинг төсөл /2012-2016 он/ Улс орнууд хүнсний баталгаат байдлыг хангах, хөдөө аж ахуйнхөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дутагдаж буй санхүүжилтыг нэмэх	Даян дэлхийн хүнсний баталгаат Байдал хөтөлбөр Төслийн баг Ц.Ванчин 99112476 ЗГ-ын 11-р байр 601-б тоот
15.	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл /2012-2016 он/ Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг дээшлүүлэх замаар ядуурлыг бууруулах	ХААХОУС Төслийн баг Д.Далантайням ЗГ-ын 11-р байр 702,703 тоот Утас: 311853, 311897 dalaid@pmpmd.mn
16.	“Монгол Улсад амьтны гаралтай	БНСУ-ын KRC байгууллага

<p>бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах”-төсөл /2013-2015/ Технологи нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах зорилго бүхий төсөл</p>	<p>Хүнсний технологийн коллежийн захирал Барамсай 99112632</p>
<p>17. Монгол Улсын Органик хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх төсөл /2014-2016/ Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стандартын шаардлага хангасан органик хүнсний сүлжээний бүх үе шатанд баталгаажуулалтын эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх, органик хүнсний үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалт гаргах, олон улсын жишигт нийцүүлэх</p>	<p>НҮБ-ын ХХААБ Үндэсний зохицуулагч Б.Чулуунцэцэг 99907641</p>
<p>18. Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх төсөл /2014-2016/ Загасны аж ахуйг дэмжих замаар хүн амын хүнсний хэрэглээнд загас, загасан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх улмаар хүмүүсийн шим тэжээллэг хоол хүнсний хэрэглээг нэмэгдүүлж эрүүл мэндийг хамгаалах юм. Хот орчмын бүсэд загасны аж ахуйг дэмжсэнээр хүмүүсийн амьжиргаанд мөн эерэгээр нөлөөлөх юм</p>	<p>НҮБ-ын ХХААБ Үндэсний зохицуулагч М.Нармандах 99781972</p>

<p>НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД</p>	
<p>19. Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр Хөтөлбөрийн зорилго: Бичил бизнес эрхлэдэг болон эрхлэх хүсэлтэй Нийслэлийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийг дэмжих арга хэмжээ - Бичил зээлд хамруулах - Иргэдийг чадавхжуулах сургалтад хамруулах - Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр холбогдох журмын дагуу нэн тэргүүнд худалдан авах - Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах боломжийг бүрдүүлэх</p>	
<p>20. 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангах төсөл Хөтөлбөрийн зорилго: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангахад төслийн зорилго оршино.</p>	

Хөтөлбөрийн хамрах хүрээ: 40-өөс дээш насны, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэн энэхүү хөтөлбөрт хамрагдана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл

- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах төсөл
- Иргэдийн эргүүл, байгаль хамгаалах, нөхөн сэргээх, осол гэтлээс сэргийлэхэд бүлгээр ажиллуулах төсөл
- Ерөнхий боловсролын сургуулийн орчимд явган хүний гарц зохицуулах төсөл

Холбоо барих хаяг:

Нийслэлийн хөдөлмөрийн газар

Утас: 7011-0502, 7012-0502 Факс: 976-11-329-752

Цахим хаяг: www.ubbirj.ub.gov.mn

21. ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨР

Ерөнхий зохион байгуулагчид: МҮХАҮТ, ХасБанк, ПЕТРОВИС ХХК, Макс групп, Энержи Ресурс ХХК

Хамтран ажиллагч: АДРА ОУБ, Хөгжлийн Шийдэл ТББ

Хөтөлбөр хэрэгжих аймгууд: УБ хот, Дархан хот, Эрдэнэт хот, дагавар хорооллууд 21 аймаг сум, харъяа суурин газрууд

Хөтөлбөрт хамруулах төслүүд:

- Эко хэрэглээ эко үйлдвэрлэл байх– Байгаль орчинд ээлтэй ажлын байр бий болгох
- Органик брэнд бүтээгдэхүүн байх- бүтээгдэхүүнийг өргөн хэрэглээ болгох хөгжүүлэх, зах зээлд гаргах бүрэн боломжтой байх
- Эко бизнесын шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн
- Өрхийн амжиргааг дээшлүүлэх, өөрсдийн үйл ажиллагааныхаа ашгаас зээлээ эргэн төлөх боломжтой жижиг дунд эко төслүүд байх

Холбоо барих хаяг:

МҮХАҮТанхимын байр 310 тоот

Махадма Гандийн гудамж, Хан Уул дүүрэг 1-р хороо , УБ хот

Хөтөлбөрийн зохион байгуулах баг

Утас: 55 25 35 33

Имэйл: info@organicmongol.mn

Web: www.organicmongol.mn

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

22. ЖДҮ-үүдэд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх зээл- ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх хөтөлбөр /QSDC/

Хөтөлбөрийн зорилго :

- Тодорхой эрэлт эсвэл гэрээг биелүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ISO, HACCP гэх мэт олон улсын чанарын системийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, стандартыг сайжруулах
- Шинэ технологи нэвтрүүлэх
- Худалдан авагчийн тодорхой шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн,

үйлчилгээ бий болгох

- Түүхий эд, материал нийлүүлэгч илүү сайн ханган нийлүүлэгч олох
- Шинэ зах зээлд нэвтрэх.

Дараах байдлаар туслалцаа үзүүлнэ:

- Санхүүгийн туслалцаа: тоног төхөөрөмж худалдан авах, урсгал зардлыг санхүүжүүлэх г.м.
- Техникийн туслалцаа: гадаад, дотоодын мэргэжилтэн олох, тэднээр зөвлөгөө өгүүлэх, ажиллагсдыг нь сургах г.м.
- ЖДҮ-ийг шинэ худалдан авагчидтай холбож өгөх, нэмэлт санхүүжилт олоход нь туслах зэргээр ХНХЧТ-ийн хамтран ажилладаг бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудтай холбож өгөх

Шалгуур үзүүлэлт:

- Тодорхой худалдан авагчтай байх. Тус төвийн туслалцаа нь тодорхой эрэлтийг (худалдах, худалдан авах гэрээтэй байх г.м.) хангахад чиглэгдсэн байдаг. Туслалцаа хүсэгч байгууллагын эрэлт, худалдан авагч бүрэн тодорхой биш байвал бид ЖДҮ-дэд хэрхэн худалдан авагчийн худалдан авах хүсэлтийг олж авах талаар анхан шатны зөвлөгөө л өгөх боломжтой.
- Тус төвийн туслалцааны үр дүнд нэмэгдэх борлуулалтын хэмжээ нь тус төвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үнийн дүнгээс доод тал нь 5 дахин их байх.

Холбоо барих хаяг

Утас: (976-11) 32 13 75

Факс: (976-11) 32 78 25

Цахим шуудан: info@qsdс.mn

Цахим хаяг: www.qsdс.mn

23. Бичил эдийн засгийг дэмжих хөтөлбөр-АДРА

Эдийн Засгийг Дэмжих хөтөлбөр нь бичил санхүү болон бизнес хөгжлийн шинэлэг, үр дүнтэй үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг шаардлагатай иргэд болон олон нийтийн өөртөө туслах чадавхийг нэмэгдүүлж орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг. Төслийн үйл ажиллагааны үр дүнд хоршооны удирдлага, гишүүдийг бизнесийн болон мэргэжлийн шат дараалсан сургалтад хамруулж ур чадвартай боловсон хүчинг бий болгоход анхаарч, ажлын байранд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, ноос, сүү цагаан идээ, газар тариалангийн чиглэлээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулдаг.

Холбоо барих хаяг:

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токиогийн гудамж,

Палаззоцамхаг, 8-401

Утас: 976-11-450734

Факс: 976-11-450726

Цахим хаяг: www.adra.org.mn

24. Европын сэргээн босголт хөгжлийн банкны Бизнесийн зөвлөх үйлчилгээ (БЗҮ) Монгол хөтөлбөр

Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн чиглэлээр зөвлөх үйлчилгээг авч, үндэсний зөвлөх мэргэжилтнийг ажиллуулахад зардал хуваалцан дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр. Зөвлөх үйлчилгээнээс санхүүжилт хүртэл хэрхэн

танд туслах ноу хау-г хуваалцах боломжтой. Төслийн цэвэр зардлын 25-75 хувийг буцалтгүй тусламжийн дээд хэмжээ €10000) олгоно.

Холбоо барих хаяг:

Жижиг Дунд Бизнесийг Дэмжих Баг

Утас: 976-11-319278 / 317974

Факс: 976-11-315844

Э-шуудан: knowhowmongolia@ebrd.com

Цахим хуудас: www.ebrd.com/sbs/mongolia

25. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл /3 дах шат нь үргэлжилнэ/-JICA

Японы олон улсын агентлаг JICA-ын эх үүсвэрээр жижиг дунд үйлдвэрлэл болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж болон үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламжийн өргөтгөлийн санхүүжилтийг хангахад оршино. Арилжааны банкуудаар дамжуулан авах боломжтой.

Зээлийн хэмжээ 400.0 мянга хүртэлх USD, түүнтэй тэнцэх төгрөг

Зээлийн хугацаа 10 жил хүртэлх

Зээлийн хүү (жил)

MNT - 7.0 %

USD - 5.0 %

26. KFW банкны төслийн зээл

Герман улсын KFW банкны эх үүсвэрээр Монгол улсын экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих төслийн зээл.

Зээлийн хэмжээ 250.0 мянга хүртэлх EUR, түүнтэй тэнцэх төгрөг

Зээлийн хугацаа 5 жил хүртэлх

Зээлийн хүү (жил)

MNT - 15.8 %

EUR - 8.5 %

Тавигдах шаардлага:

1. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх;
2. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
3. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх;
4. Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх;
5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх;
6. Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгөтэй байх;
7. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

27. Азийн Хөгжлийн банкны АБНТЗээл

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, ажлын байр шинээр бие болгох иргэд болон аж ахуйн нэгжийн зээл.

Зээлийн хэмжээ 30 сая хүртэл төг

Зээлийн хугацаа 24 сар

Зээлийн хүү (жил) 10%

Тавигдах шаардлага:

1. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх;

2. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
3. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх;
4. Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх;
5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх;
6. Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгөтэй байх;
7. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

Холбоо барих хаяг:

Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
СБД, 2-р хороо, М Си Эс Плаза, Чингисийн өргөн чөлөө, 2 давх, (1-р сургуулийн
замын урд) УБ 14251

Утас: 329836, 323507

Факс: 311795

И-мэйл: adbmnrm@adb.org

Цахим хуудас: www.adb.org/mnrm

28. **Азийн Хөгжлийн банкны АБНТЗээл**

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, ажлын байр шинээр бие болгох иргэд болон аж ахуйн нэгжийн зээл.

Зээлийн хэмжээ 30 сая хүртэл төг

Зээлийн хугацаа 24 сар

Зээлийн хүү (жил) 10%

Тавигдах шаардлага:

1. Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх;
2. 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
3. Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх;
4. Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх;
5. Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх;
6. Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгөтэй байх;
7. Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

Холбоо барих хаяг:

Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
СБД, 2-р хороо, М Си Эс Плаза, Чингисийн өргөн чөлөө, 2 давх, (1-р сургуулийн
замын урд) УБ 14251

Утас: 329836, 323507

Факс: 311795

И-мэйл: adbmnrm@adb.org

Цахим хуудас: www.adb.org/mnrm

/Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим/